



НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 04 сарын 25 өдөр

Дугаар А/36

Улаанбаатар хот

Сүхбаатар дүүргийн 25 дугаар
цэцэрлэгийн эргэлтийн бус хөрөнгийг
балансаас баланст шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэг, “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2023 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Сүхбаатар дүүргийн 25 дугаар цэцэрлэгийн эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй 83,349,000 (наян гурван сая гурван зуун дөчин есөн мянга) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг балансаас баланст шилжүүлсүгэй.

2.Балансаас баланст шилжүүлж буй дээрх хөрөнгийг данс бүртгэлээсээ хасахыг Сүхбаатар дүүргийн 25 дугаар цэцэрлэг (С.Батцэцэг), хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, зарчим, холбогдох хууль, журмыг баримтлан бүртгэж авахыг Сүхбаатар дүүргийн 234 дүгээр цэцэрлэг (Ц.Дариймаа)-т тус тус даалгасугай.

3.Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Сүхбаатар дүүргийн 25 дугаар цэцэрлэг (С.Батцэцэг), Сүхбаатар дүүргийн 234 дүгээр цэцэрлэг (Ц.Дариймаа)-т тус тус үүрэг болгосугай.

4.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, ашиглалт, дотоод аудитын хэлтэс (Ц.Цэрэндулам)-т даалгасугай.


ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Ч.САЙХАНБАЯР

1150500039

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын
2023 оны ...04... дугаар сарын 25... өдрийн
А/36... дугаар тушаалын хавсралт



Балансаас баланст шилжүүлэх хөрөнгийн жагсаалт

Байгууллага : Сүхбаатар дүүргийн 25 дугаар цэцэрлэг

№	Эд хөрөнгийн нэр	Ашиглал- танд орсон огноо	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Хуримт- лагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг	Шилжүүлэн авах байгууллага
Машин тоног төхөөрөмж									
1	Хүүхдийн ор	2022	ш	189	441,000.00	83,349,000.00	0.00	83,349,000.00	СБД-ийн 234 дүгээр цэцэрлэг
Нийт хөрөнгийн дүн						83,349,000.00	-	83,349,000.00	